

## Ээлжит хичээлийн хөтөлбөр-4

**Сэдэв:** Параллель зөөлт

**Хугацаа:** 40 минут

**Зорилго:** Параллель зөөлт хувиргалтын шинж чанарыг мэдэх, дүрсийг параллель зөөлт хувиргалтаар хувиргах




**Зорилт:**


- Параллель зөөлт хувиргалтыг таних
- Дүрсийг параллель зөөлтөөр хувиргах
- Дүрсийг өгсөн чиглэлд тодорхой зайд шилжүүлэх

**Агуулга:**

Өмнө судалсан агуулга	Цаашид судлах агуулга
- Өмнө судлагдаагүй. Шинэ ойлголт.	- Параллель зөөлт хувиргалтаар хэрчмийн урт, өнцөг хадгалагддаг гэдгийг ойлгох, хэрэглэх

**Цагийн төлөвлөлт:**

Хичээлийн бүтцийн явц	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Хичээл зохион байгуулалт - 1 минут	- Сурагчидтай мэндлэнэ - Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.	- Багштай мэндлэнэ - Сурагчид хичээлийн бэлтгэл байдлыг хангана.
Сэдэлжүүлэлт - 5 минут	<p>Алхам 1 Машин чигээрээ 9м яваад зогсов.Ямар хөдөлгөөн хийж байна вэ?</p> 	
Шинэ мэдлэг бүтээх - 15 минут	<p>Дүрсээ байгуулж, хувиргалтаа хийх/ Туршилт-1</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өгсөн цаасыг 4 тэнцүү гурвалжин болгоорой.</li> <li>- Нугалсан гурвалжингуудаа нугалсан хэсгээрээ хайчилж хуваагаарай.</li> <li>- 1 дүрсээ тэгш өнцөгт гурвалжин хэлбэрээр дэвтэртээ наагаарай.</li> <li>- Наасан гурвалжингуудын орорйнуудыг А,В,С үсгээр тэмдэглээрэй.</li> </ul>	<p>Хичээлийн гол агуулгаа ойлгож тодорхойлолтоо бичих Параллель зөөлт хувиргалтыг таних, хийх аргаа сурах Кординатын хавтгайд дүрсээ байгуулж параллель зөөлт хувиргалтаа хийх</p>
Бататгах - 10 минут	<p>2. Дүрсийг дээш нь 3 нэгж, зүүн тийш 2,нэгжээр зөөнө үү? Аль чиглэлд зөөгдсөн? - Хэлбэр хэмжээ нь өөрчлөгдсөн үү? - Гурвалжны орой бүрийн цэгийн байрлал шилжихдээ ямар зайд шилжсэн бэ?</p> 	<p>Зөөгдсөн дүрсийн чиглэл, хэдэн нэгжид шилжсэнийг тодорхойлж чадна. Сурагчид зааврын дагуу даалгаврыг гүйцэтгэнэ. А-А<sup>1</sup>, В-В<sup>1</sup>, С-С<sup>1</sup>, D-D<sup>1</sup> хүртэлх зайг хэдэн нэгж байгааг тэмдэглэх</p> 

<p>Дүгнэлт - 2 минут</p>	<p>ABC гурвалжингийн оройн цэг бүрийг доош 5 нэгж зайд зөөж тэмдэглэе. Гурвалжингаа зөөж <math>A_1, B_1, C_1</math> гэж тэмдэглээрэй.</p>	
<p>Гэрийн даалгавар - 2 минут</p>	<p>Дасгал <math>A_1, B_1, C_1</math> гурвалжингаа баруун гар тийш 12 нэгж, дээшээ 4 нэгж зайд зөөгөөрэй. Зөв зөөлт хийсэн бол дэвтэртээ наагаарай. Гурвалжны оройг <math>A_2, B_2, C_2</math> гэж тэмдэглээрэй</p>	